

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл.....	2
1.2. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга.....	2
1.2.1. Байршил.....	2
1.2.2 Уурхайн өнөөгийн байдал.....	3
1.2.3 Ил уурхайн техникийн хил хязгаар ба алтны нөөц	3
1.2.4 Уурхайн жилийн хүчин чадал.....	3
1.2.5 Уурхайн тоног төхөөрөмж	4
1.2.6 Уурхайн дотоод тээвэр	5
1.2.7 Хүний нөөц, дэд бүтэц барилга байгууламж.....	5
1.2.8 Ажилчдын бүтэц бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт	5
1.2.9 Уурхайн дэд бүтэц	5
1.2.10 Уурхайн тосгон	6
1.2.11 Уурхайн усан хангамж	6
1.2.12 Усны хэрэглээ.....	7
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
3.1. Агаарын чанарт үзүүлэл нөлөөллийг бууруулах.....	12
3.2. Усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах	13
3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	13
3.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.....	16
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	18
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл

Хүснэгт 1. “Монгол Экспресс Эм Эн” ХХК-ийн аж ахуйн нэгжийн мэдээлэл


Аж ахуй нэгжийн нэр	“Монгол Экспресс Эм Эн” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011317087
Регистрийн дугаар	5533538
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, 6/3,22 тоот
Утас	(+976) 99116225, 11-319193

1.2. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

Энэхүү төслийн үндсэн зорилго нь Цагаан гозгорын алтны шороон ордоос алт олборлож, баяжуулан дотоодын зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ. Ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 75.11 мян.м3 элс, 1.133 гр/м3 агуулгатай элсэн дэхь алт нь 85.11 кг буюу химийн цэврээр 74.48 кг алтны нөөцтэй. Үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 92.19 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 78.47 кг шлихийн алт, химийн цэврээр 68.66 кг алт үйлдвэрлэнэ.

1.2.1. Байршил

“Монгол экспресс Эм Эн” ХХК-ийн MV-007978 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун хойш 190 км, Төв аймгийн Цээл сумаас хойш 25 км-т байрлана.




Зураг 1. Төслийн байршил

1.2.2 Уурхайн өнөөгийн байдал

Уурхайн одоогийн байдал: “Монгол экспресс Эм Эн” ХХК нь өмнө нь олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд тус уурхайд контейнер ба сэндвичэн байшин бүхий ажилчдын хотхон, тунаах болон цэвэр усны нуур, уурхайн баяжуулах төхөөрөмж хүртэл татсан 3.4 км-ийн ган хоолой бүхий 1 гүний худагтай, худгийн ЭЦВ-6 болон 8 насос суурилуулсан. 10/0.4 кв өөрийн цахилгааны шугамтай, 250 болон 400 кВа-ийн трансформаторуудтай байна.

1.2.3 Ил уурхайн техникийн хил хязгаар ба алтны нөөц

Тус орд нь III бүлгийн ордод хамаарах бөгөөд Монгол улсын Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ыг үндэслэн бодитой В, боломжтой С зэрэглэлийн нөөцөд тулгуурлан ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.



Зураг 2. Ордын нөөцийн дэвсгэр зураг

1.2.4 Уурхайн жилийн хүчин чадал

Төсөл хэрэгжүүлэгчийн өөрийн тоног төхөөрөмжүүд болох HYUNDAI R520LC, экскаватор, MT-86 маркийн автосамосвал, СЕМ-650В утгуурт ачигч, CAT-D6 маркийн бульдозер гэх мэт техникүүдийн бүтээлийн тооцоог үндэслэн жилийн хүчин чадлыг оновчилж гаргасан байна. Уурхайг нийт 2 жилийн хугацаанд олборлож 3 дахь жилд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ. Төслийн нийт үргэлжлэх хугацаа 3 жил байна.

Ордын нээлт: Уурхайн хойд талдаа хөрс хуулалт хамгийн багатай хэсэг С-3, В-8 блок буюу ХШ-8,9-ын хэсгээр уурхайн нээлтийг хийнэ. Газрын гадарга дээр $X = 512834.8181$ $Y = 5389154.8510$ координатаас баруун хойшоо чиглэлтэй уурхайн ерөнхий ханыг дагаж +1008 м-ийн түвшингээс +996 м түвшин хүртэл дотоод ерөнхий траншей нэвтэрнэ. Түүнээс цааш

ажлын доголын өндрөөр бүлэг траншей нэвтэрч явах ба +984 м түвшин буюу нөөцийн ул хүртэл 12 м өргөн, 80 0 /00-ийн налуутай траншей нэвтэрч ордын нээлтийг хийнэ.

Ордын нээлтийн үед 24 м өргөн, дунджаар 35 м урт, авахад бэлэн нөөцийн таазыг гаргахад ил уурхайн хүрээ нь дунджаар 165 м урт, 111 м өргөн болж нийт 338.0 мян.м3 хөрс хуулна. Хөрсийг нээлтийн талбайн хойд талд хуучин олборлолтоор эвдэгдсэн ухашд нөхөн дүүргэлт хийх ба энэ нь уурхайн амнаас 352 м зайд байрладаг. Шимт хөрсийг шимт хөрсний овоолгод хураана, ингэхдээ овоолгын суурийн талбайгаас 0.3 м зузаантай шимт хөрсийг хуулах ба ордын нээлтэнд нийт 5.7 мян.м3 шимт хөрс хуулж шимт хөрсний овоолгод хураана. Үүнээс цааш ил уурхай нь суналын дагуу ахилт явагдах ба дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийх боломж бүрдэж өгнө.

Уулын ажлын төлөвлөлт: Уулын ажлын жилийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаатай уялдуулж дараах календарчилсан төлөвлөгөөг тооцоолов. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 3,352.3 мян.м3 хөрс хуулж, дунджаар 1,075.91 мг/м3 агуулгатай 85.66 мян.м3 элс олборлон, химийн цэврээр 80.57 кг металл олборлохоор байна.

Бүтээгдэхүүн гаргалт: Төсөл хэрэгжих хугацаанд нийт нийт 3,351.0 мян.м3 хөрс хуулж, 75.11 мян.м3 элс олборлон дунджаар 1.133 гр/м3 агуулгатай химийн цэврээр 74.48 кг алт олборлоно. Үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 92.19 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 78.47 кг шлихийн алт, химийн цэврээр 68.66 кг алт үйлдвэрлэнэ.

1.2.5 Уурхайн тоног төхөөрөмж

Төсөл хэрэгжүүлэгч “Монгол экспресс Эм Эн” ХХК нь дараах өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжүүдтэй ба Цагаан гозгорын алтны шороон ордын ил уурхайд дараах техникүүдээс ашиглахаар төслийг боловсруулсан байна.

Хүснэгт 2.Төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшлийн тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Хүчин чадал	Тоо ширхэг
1.	Экскаватор	Hyundai R520LC	3.2м3	4
2.	Автосамосвал	MT-86	60тн	10
3.	Бульдозер	CAT-D6	3,8м3	1
4.	Утгуурт ачигч	CEM-650B	3.2м3	3

Хүснэгт 3.Ил уурхайн процесс

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй, гадаад дотоод овоолготой ашиглалтын систем	Хөрс хуулалт	Шимт хөрс түрэх, ухаж ачих тээвэрлэх
		Хөрс хуулах
		Хөрс тээвэрлэх
		Дотоод овоолгод буулгах
		Овоолго түрэх
	Олборлолт	Ухаж ачих
		Тээвэрлэх
		Түр овоолгод буулгах, угаах
		Эфел гааль тээвэрлэх

Шимт хөрс хуулах: Шимт хөрсийг ил уурхай, шимт хөрсний овоолго, замын болон бусад барилга байгууламжийн суурийн талбайгаас 0.3 метрийн зузаантайгаар хуулна. Нийт 24.1 мян.м3 шимт хөрс хуулж овоолгод хураана. Бульдозерын түрж овоолсон шимт хөрсийг СЕМ-650В маркийн утгуурт ачигч, МТ-86 маркийн автосамосвалын хослолоор шимт хөрсний овоолгод хураана.

1.2.6 Уурхайн дотоод тээвэр

Уурхайн дотоод тээвэрт МТ-86 маркийн 28 м3 тэвшний багтаамжтай автосамосвааар шимт хөрс, хөрс, элс тээвэрлэнэ. Төсөл хэрэгжих хугацаанд 24.17 мян.м3 шимт хөрс, 3,326.8 мян.м3 хөрс, 75.1 мян.м3 элс тээвэрлэнэ.

Маршрут-1: Шимт хөрсийг шимт хөрсний овоолго хүртэл тээвэрлэхдээ хамгийн холдоо 730 м, ойрдоо 100 м хүртэл зайнаас тээвэрлэлт хийнэ.

Маршрут-2: Капитал ажлын 338.0 мян.м3 хөрсийг хуучин олборлолтоор эвдэгдсэн хоосон орон зайд нөхөн дүүргэлт хийх ба уурхайн ёроолоос хөрс тээвэрлэн нөхөн дүүргэлт хийх талбай хүртэл 680 м байна.

Маршрут-3: Дотоод овоолгод нөхөн дүүргэлт хийх 2,988.8 мян.м3 хөрсийг экскаваторын ажиллах хөрсний мөргөцөгөөс дотоод овоолгын талбай хүртэл тээвэрлэж буулгана.

Маршрут-4: Ил уурхайгаас баяжуулах үйлдвэрийн түр овоолгын талбай хүртэл элс тээвэрлээд буцах замдаа эфель гааль тээвэрлэж дотоод овоолгын талбай хүртэл явна. Дээрх маршрут бүрийн замын уртуудыг харгалзан шимт хөрс, хөрс тээвэрлэх замын уртыг дунджаар 500 м, элс тээвэрлэж явах замын уртыг 650 м байхаар тооцсон байна.

1.2.7 Хүний нөөц, дэд бүтэц барилга байгууламж

1.2.8 Ажилчдын бүтэц бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт

Ажилчдын орон тоог төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи, төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрийг харгалзан тооцсо байна. Төслийн хүчин чадлыг эзэмших, түүнд хүрэхийг зорих хангалттай тооны ажилчдыг тусгаж өгсөн бөгөөд ордын хувьд 2 ээлжээр ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Цагаан гозгорын алтны шороон ордын уурхайд нийт 92-108 хүн ажиллах бөгөөд 1 ажилтны сарын дундаж цалин 1.86 сая төгрөг байна. Уурхай ашиглалтын 2 жилийн хугацаанд ЭМД, НДШ-д байгууллага 293.48 сая.төг, хувь хүн 232.76 сая.төг төлөх бол ХХОАТ-т 171.64 сая.төг төлөхөөр байна.

1.2.9 Уурхайн дэд бүтэц

Цагаан гозгорын алтны шороон ордыг ашиглахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цахилгаан хангамж, дулаан хангамж, хотхоны барилга, зам болон харилцаа холбоог доор тусгав. Цагаан гозгорын алтны шороон ордын уурхай нь үндсэн 5 хэсэг ба дагалдах хэсгүүдээс бүрдэнэ.

1. Төв оффис
Уурхайн удирдлагын байр
2. Ил уурхай
Ил уурхай, хөрс, элсний овоолго
3. Баяжуулах хэсэг

- Угаах тоног төхөөрөмж, элсний овоолго
4. Засвар үйлчилгээ, хангамжийн хэсэг
Засварын алба, шатахуун түгээх станц, хангамжийн алба
5. Тосгон, үйлчилгээний хэсэг
Тосгон үйлчилгээний алба, эрүүл мэндийн төв, харуул хамгаалалтын алба, холбоо

1.2.10 Уурхайн тосгон

Ажилчдын сууц. Уурхайн ажилчдын хотхоныг нэг дор 57 хүн, нөөц тооцсоноор 62 хүн зэрэг байрлах хүчин чадалтайгаар төлөвлөж шаардлагатай барилга байгууламж, тавилга, эд хогшлыг тооцсон байна. Ажилчдын сууцыг 350м² талбай бүхий сендвичээр барьж байгуулан засч тохижуулан хүн амьдрах тав тухыг бүрдүүлсэн байна.

Хоолны газар. Цайны газар 40м² хэмжээтэй зөөврийн сууц байхаар засч тохижуулан хүн тав тухтай хоолох орчныг бүрдүүлсэн байна. Зөөврийн сууцанд 1 удаадаа 20-25 хүн зэрэг хооллох бөгөөд 1 хүнд дунджаар 1.55 м² талбай ноогдож байна.

Холбооны байгууламж. Уурхайн тосгонд Мобиком болон Юнителийн үүрэн телефоны сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

Түлшний агуулах. Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 21-30 хоногийн нөөц буюу 110 тонн түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

Засвар механикийн барилга байгууламж. Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын талбайд хийж гүйцэтгэнэ. Засварын талбайд дугуй засвар, гагнуур, компрессорын станц зэргийг эхний ээлжинд байгуулна.

Цахилгаан хангамж. Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Салхит Цагаан гозгор дахь “Монгол экспресс Эм Эн” ХХК-ийн 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас 10/0.4кВ-ын хүчдэлтэй 400кВа болон 250кВа-ын суурилагдсан хүчин чадалтай дэд станц угсарч уурхайг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/-ээр хангаж байна.


1.2.11 Уурхайн усан хангамж

Унд ахуйн ус хангамж. Төслийн унд ахуй, зам талбайн тоосжилт, ногоон байгууламжийн ус хэрэглээг төслийн талбайд байрлах тус бүр 2.0л ундаргатай 1 худгаас хангах нь хүрэлцээтэй байна.

Уурхайн технологийн ус хангамж. Уурхайн технологийн усны хэрэгцээг өмнө ашиглаж байсан үүсмэл нуурыг үргэлжлүүлэн ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан. Алт агуулсан элсийг скруббер төхөөрөмжөөр угааж задлан баяжуулсны дараа +10 мм ангилал нь гааль, - 10 мм ангилал нь эфель болон хаягдана. Хаягдлыг /эфель, гааль/ дотоод овоолгод овоолох

бөгөөд булингыг уурхайн ёроолд зумпфэнд хуримтлуулан зумпфнээс насосоор соруулан 72.3мянм³ эзэлхүүнтэй тунаах нуурт хоолойгоор дамжуулан шахна.

32.5 мян. м³ багтаамж бүхий технологийн цэвэр усны нууранд сэлбэх ус хангамжийн эх үүсвэрийг Цагаан гозгороос эх авах шар усны болон хур борооны усны үерийн үед урсац үүсдэг онцлогтой жалга-4 –ийн зүүн сайрын үерийн усаар хангахаар төлөвлөсөн байна.



Зураг 3. Уурхайн технологийн цэвэр усны нуур

1.2.12 Усны хэрэглээ

Цагаан гозгорын алтны шороон ордыг ашиглахад үүсэх ус хэрэглэгчдийг үндсэн гурван хэрэглэгч болгон авч үзлээ. Үүнд:

- Унд-ахуйн
- Ил уурхай
- Баяжуулах үйлдвэр
- Унд-ахуйн усны хэрэглээ

Унд ахуйн усны хэрэглээг одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа БОНХАЖА-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батласан нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын 12 дугаар хавсралтыг үндэслэж тооцов. Цагаан гозгорын төсөл нь 2 жил үргэлжлэх бөгөөд эхний жил 51 хоног, 2 дахь жилд 155 хоног 112 хүн ажиллахаар аар ТЭЗҮ-д тусгажээ.

Хүснэгт 4.Төслийн унд ахуйн усны хэрэглээ

Төслийн хугацаа		Хүний тоо	Усны хэрэглээ		Нийт м3
Эхний жил	51 хоног	112	0.06	5.6	285.6
2дохь жил	155хоног	112	0.06	5.6	868

Цагаан гозгорын ордыг ашиглах үед хотхоны унд-ахуйн усны хэрэглээнд ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 1.15 мян.м3 ус хэрэглэхээр байна.

Угаан баяжуулах усны хэрэглээ. Цагаан гозгорын шороон ордын 1 м3 элс 4 м3 ус ашиглах ба технологийн ус ашиглах ба эхний жил Угаан баяжуулах хэсэг нь эхний жил бичиг баримтын бүрдлээс шалтгаалан 08 дугаар сарын 15-наас бэлтгэл ажил 15 хоног явагдан 09 дүгээр сарын 01-нээс 45 хоног ажиллаж эхлэхээр тооцсон бөгөөд 2 дахь жилд 04 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 30- ныг дуустал 195 хоног 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12цаг байхаар тооцсон. Уг төсөлд 72.9%-ийг эргэлтэд буцааж ашиглавал үлдсэн хувийг цэвэр усаар хангана.

Хүснэгт 5.Элс угаахад шаардлагатай цэвэр ус

Ашиглах жил	Угаах элс мян.м3	Ажиллах хоног	Нийт хэрэглээ мян.м3/хоног	27.1%-ийг нөхөн сэлбэх усны хэмжээ м ³ /хоног	27.1%-ийг нөхөн сэлбэх усны хэмжээ л/сек	Нөхөн сэлбэх ус м ³ /жил
1-р жил	27.12	51	108.48	57.3	6.65	29 289.6
2-р жил	58.54	155	234.16	407.9	4.72	63 457.4
Нийт	169 126.4	-	342.64	-	-	

Хүснэгт 6.Замын тоосжилт дарах усны хэрэглээ

Усалгааны хугацаа	Талбай	Норм	Усны хэрэглээ		
			л/сек	м3/хоног	Нийт мян.м3
62	2992	2.0	0.065	5.98	371.0

Ногоон байгууламжийн усны хэрэглээг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13-р хавсралтаар 1 ширхэг модны усалгааг 15.0 литр байхаар тооцов.

Хүснэгт 7. Ногоон байгууламжийн усалгаа

Усалгааны хугацаа	Ногоон байгууламж	Норм, л/м2	Усны хэрэглээ		
			л/сек	м3/хоног	Нийт хэмжээ
30 хоног	Мод 600ш	15.0	0.09	9.0	135.0

Нийт ус хэрэглээ . Уурхайн баяжуулах төхөөрөмж хүртэл татсан 3.4 км-ийн ган хоолой бүхий 2 гүний худагтай, худгийн ЭЦВ-6 болон 8 насос суурилуулсан.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Цагаан гозгор”-ын Жалга-4 хэсгийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг Монгол Улсын Засгийн Газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014 оны 04-р сард А-117 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэв. Мөн нөлөөллийн оноот үнэлгээний аргыг ашиглан нөлөөллийн үр дагавар, түүнд өртөх нутаг дэвсгэр болон байгаль орчны чадамжид оноо өгч дүгнэлт гаргав. Шалгуур онооны үзүүлэлтийг дараах байдлаар авч үзэв. Үүнд:

Хүснэгт 8.Нөлөөллийн үзүүлэлт ба оноо

Тэмдэглэгээ	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт	Нөлөөллийг үнэлэх оноо		
Н	Нөлөөлөл	Эерэг (1)	Сөрөг (-1)	Нөлөөгүй (0)
A1	Байгаль орчны сүйрэл	Их (3)	Дунд (2)	Хязгаарлагдмал (1)
A2	Байгалийн нөөц, орчны чанарт учруулах нөлөө	Их (3)	Дунд (2)	Бага (1)
A3	Тохиолдол магадлал	Их	Магадлалтай	Магадлал бага
B1	Нөлөөллийн хамрах хүрээ	Бүсийн	Орон нутгийн	Маш бага талбайд
B2	Үргэлжлэх хугацаа	Урт	Дунд	Богино
C1	Нөхөн сэргээгдэх чадвар	Үл сэргээгдэх	Хэсэгчлэн сэргээгдэх	Бүрэн сэргээгдэх

(A1).- Байгаль орчны сүйрэл

(A2)- Байгалийн нөөц ба хүрээлэн буй орчны чанарт үзүүлэх нөлөө

(A3)- Янз бүрийн тохиолдол

Үр нөлөөний хамрах хүрээ

(B1)- Орон зайгаар

(B2)-Үргэлжлэх хугацаагаар

Сөрөг нөлөөллийг даах байгалийн чадавхи

(C1)-Нөхөн сэргээгдэх байдал

(Н)-Нөлөөллийг эерэг, сөрөг ба нөлөөлөлгүй гэсэн ангиллаар авч үзнэ.

Нөлөөллийн үзүүлэлт ба оноог хүснэгтэд, нөлөөллийн зэргийн шалгуурыг 2.2-р хүснэгтэд тус тус харуулав.

Нийлбэр нөлөөллийн зэргийг $H \cdot (A1+A2+A3+B1+B2+C1)$ томъёогоор илэрхийлэв.

Хүснэгт 9.Нөлөөллийн зэргийн үнэлэмж

Сөрөг нөлөөлөл		Эерэг нөлөөлөл	
Их	<-15	Их	+15<
Дунд	(-15,-9)	Дунд	(+9,+15)
Бага буюу нөлөөгүй	-9<	Бага	<+9

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бүрийн хамрах цар хүрээ болон тохиолдох магадлал хир байгааг өгөгдөл цуглуулах болон өгөгдөлдөө задлан шинжилгээ өгөх замаар экспертүүд

Хүснэгт 10. Уур амьсгалын хүчин зүйлээс үүсэх нөлөөлөл

Хүснэгт 11. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

№	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийн онооны үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
		Н	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C	Σ	
1	Уулын ажлын явцад үзүүлэх тоос	-1	2	3	3	1	1	2	-12	Их
2	Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт	-1	2	3	3	1	1	2	-12	Их
3	Бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас хийсэх тоос шороо	-1	2	1	2	1	3	1	-10	Дунд
4	Хөрсний овоолго үүсгэснээс гарах тоос	-1	2	2	2	1	2	1	-12	Дунд
5	Машин механизмын дуу чимээ	-1	2	1	3	2	2	2	-12	Их
6	Уурхайн механизмуудын яндангаас ялгарах хорт хий, уурын зуухнаас ялгарах хорт хий	-1	2	1	2	2	2	1	-10	Дунд
Дүгнэлт		Нийт нөлөөллийн 50% нь дунд, 50% нь их гэсэн ангилалд багтаж байгаа нь алтны уурхайн төслөөс туханй нутгийн агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн зэргийг ИХ гэж дүгнэж байна.								

Хүснэгт 12. Газрын гадарга хэвлийд үзүүлэх нөлөөлөл

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн онооны үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
		Н	A1	A2	A3	B1	B2	C1	Σ	
1	Газрын нөөц багасах	-1	2	2	2	2	2	2	-12	Дунд
2	Ач холбогдолгүй чулуулгаар бүрхэгдсэн талбай үүсэх	-1	2	2	2	1	2	2	-10	Дунд
3	Огцом хэлбэр бүхий гадаргуу үүсэх	-1	2	2	2	1	2	2	-10	Дунд
4	Үүсмэл ландшафт	-1	2	2	2	1	2	2	-10	Дунд
5	Газрын гадаргын хэв шинжийн өөрчлөлт	-1	2	2	-1	2	2	2	-10	Дунд
6	Газрын хэвлийд хоосон орон зай үүсэх	-1	2	1	1	2	2	1	-9	Бага
Дүгнэлт		Дээрх нөлөөллүүдийг бууруулах юмуу арилгах аргагүй тул дунд гэсэн ангилалд орж байна. Гэхдээ энэхүү нөлөөллийг хамрах хүрээ нь тухайн заасан хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд төсөл дууссан хойно тус газрыг нөхөн сэргээх, эргэн тохижуулах боломжтой тул нөлөөлөл харьцангуй бага гэж үзнэ. Дээрх дурьдсан нөлөөллүүдийг 16,7% бага, 66,8% нь дунд сөрөг нөлөөллөтэй.								

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ бүлгийн зорилго нь төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, үргэлжлэх эрчим ба цар хүрээг тогтоох нөлөөллийг бууруулах буюу зайлсхийх, багасгах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр зорьж ажиллав.

3.1. Агаарын чанарт үзүүлэл нөлөөллийг бууруулах.

Хүснэгт 13. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэх ажил	Биелэлт	Хавсралт
1	Уурхайд ашиглаж байгаа машин техникийн хөдөлгөөний, алт олборлох үед, хөрс шороо ачиж буулгах, шимт болон шимэрхэг хөрсний овоолго, дотоод тээврийн зам зэргээс үүсэх тоосжилт	Уурхайлалтын үйл ажиллагааны үед хуурайшилттай байх тохиолдолд усалгааг тогтмол хийх	Жилийн 4-9 сард нийт 37 удаагийн усалгаа хийсэн.	Хавсралт 1. Усалгаа хийсэн бүртгэл
2		Шатах тослох материал хадгалах сав, машин механизмуудын хорт хий ялгаруулалтанд хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол хийж, хорт хийн ялгаралтыг стандарт түвшинд барьж ажиллах	Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа машинуудад утаа шүүх шүүлтүүр тавьсан.	Хавсралт 2. Утааны шүүлтүүрний зураг
3		Ахуйн хэрэгцээнээс гарсан шингэн хаягдал цуглуулах цэгийг хөрс бохирдуулахгүйн тулд бүрэн бүтэн байдлын хянаж засвар үйлчилгээг хангаж ажиллах	Ахуйн бохир усны шугам хоолойг жил бүр хяналт хийж ажилласан.	Эвдрэл гэмтэл байхгүй.
4		Ахуйн хатуу хог хаягдлыг ангилж хаях, ус нэвтрэхээргүй, таглаатай, газарт хатуу урсац нэвчихээргүй суурьтай болгон тохижуулах	Хог хаягдал ангиан ялгах савыг байршуулсан.	Хавсралт 3. Хог хаягдлын сав зураг
5	Машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, шатах тослох материалын ууршилт, ажилчдын суурингаас бохирдуулагч бодис агаарт тархах	Ашиглагдаж буй замын дагуу тэмдэг тэмдэглэгээ тавих, олон салаа зам гаргахгүй талаар арга хэмжээ авч, ажилчид албан хаагчдад үүрэг өгч байх, хурдны хязгаарыг тогтоож ажиллах	Замын тэмдэг тэмдэглэгээг үасварлан сайжруулах, хурдны хяугаарыг барих, өдөр тутмын зааварчилгааг тухайн өдөр бшрт ажилчдад өгөх ажлуудыг хийж гүйцэтгэв.	Хавсралт 4. Замын тэмдэг тэмдэглээний зураг, зааварчилгааны зураг
6		Уурхайн тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааг шалгаж байх, техник тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Техникийн үзлэгийг тогтсон хуваарийн дагуу хийсэн.Авто засварын төв шинээр байгуулсан.	Хавсралт 5. Авто засварын байгууламжийн байр
7		Машин техникийн тос тосолгооны материалын хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулан зориулалтын цэгт хүргэх	“Хайби Ойл” ХХК-д өөрийн тээврээр 800л тос хүргүүлсэн.	Хавсралт 6. Гэрээ
Нийт			1 100.0	

3.2. Усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах

Үйлдвэрийн ойр орчимд гадаргын усны нөөц байхгүй. Харин үйл ажиллагаанд усыг унд ахуйн хэрэгцээнд болон зам болон ногоон байгууламжийг услахад ашиглаж байна.

Хүснэгт 14. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Биелэлт	Хавсралт
1	Төслийн үйл ажиллагааны улмаас гүний усанд бохирдол үүсэх, гүний усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Ахуйн бохир ус зайлуулах цооногийг бүрэн бүтэн байдлын ханган ажиллах	Шугам хоолойн бүрэн бүтэн байдлын хяналтыг хуваарийн дагуу хийсэн.	Хавсралт 8. Хяналт шалгалтын байдал
2		Бохир ус болон үерийн ус зайлуулах суваг хоолойн оруулга, гаргалгын бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор байнга хяналт тавин ажиллах	Үерийн ус зайлуулах шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг ханган засвар үйлчилгээг хийсэн.	Хавсралт 9. Зураг
3		Ус ашиглах гэрээ хийж усны төлбөрөө төлөх	Ус ашиглах гэрээ болон түүний дагуу усны төлбөрийг төлөн ажилласан.	Хавсралт 10. Усны гэрээ болон төлбөрийн баримт
4		Унд-ахуйн хэрэглээнд ашиглагдаж буй гүний худгийн усыг ОХШХ-ийн дагуу шинжилгээг хийлгэх	Ус цаг уурын орчны шинжилгээний газартай хийсэн гэрээний дагуу 2 удаа ус, хөрс, агаарын шинжилгээ хийгдсэн.	Хавсралт 11. Шинжилгээний хариу
5				
Нийт				

3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 15. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Биелэлт	Хавсралт
1	Уурхайлалтын шууд нөлөөллөөр байгалийн ургамалжил устгах	Уурхайлалтын явцад олон тооны машин техник ажиллах тул тэдгээрийн хөдөлгөөний чиглэл явах маршрутыг нарийн төлөвлөж, олон салаа зам үүсгэхгүй байхыг анхааруулах, жолооч ажилчдад байгаль орчинтой зөв харьцаж, хамгаалах талаар зөвлөгөө сургалт явуулж, хяналт тавих;	Өдөр бүрийн зааварчилгаа өгөхөд хурдны хязгаарыг барихыг анхааруулан ажилланасн бөгөөд байгаль хамгаалах хог хаягдлын сургалтыг 2 удаа зохион байгуулсан.	Хавсралт 12. Хог хаягдлын сургалтын зураг, сургатын материал

3.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Газрыг зөв зохистой ашиглахтай холбоотой Монгол Улсын хууль, тогтоомжуудын шаардлагууд, байгаль орчны стандартууд болон төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний шаардлагуудад нийцүүлэн ажиллах зорилтын хүрээнд төлөвлөгөөг боловсрууллаа. Бид аливаа үйл ажиллагаанаас газар хөндөх, хөрс хуулах ажилд хяналт тавьж, шимт хөрсийг стандартын дагуу хадгалах, тухайн талбайд шаардлагатай нөхөн сэргээлтийг төлөвлөхөд онцгой анхааран ажиллаж байна.

Хүснэгт 16.. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Биелэлт	Хавсралт
1	Хөрсний үе давхарга холилдон, гадарга дээр хөрс үүсгэгч эх чулуулгууд ил гарах	Уурхайн малталтыг дүүргэж, тэгшлэх, шимт хөрсөөр талбайг хучих, тэгшилсэн талбай дээр дэвссэн хөрсний үеийг тэгшлэх, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх боломжоор хангах	Төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэв.	Хавсралт 13. Нөхөн сэргээлтийн зураг
2		Шимт хөрсний овоолгын шинж чанарыг алдагдуулахгүй байх арга хэмжээг авч байх, нөхөн сэргээлтэд ашиглах	Шимт хөрсний чанраыг сайжруулах үр цацах ажил	Хавсралт 14.Нөхөн сэргээлтийн зураг
3		Шимт хөрсийг сайжруулах арга хэмжээ авах		

3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр болон үйл ажиллагааны явцад дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэсэн төрлөөр ангилж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ыг баримталж ажиллах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

Ахуйн хог хаягдал: Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн дагуу хог хаягдлыг арилгах ажлыг зохион байгуулна. Хаягдлын байгууламжийн байршлыг нь хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд халгүй газар сонгон байршуулж, устгах ажлыг зохион байгуулах шаардлагатай. Уурхайд нийт 112 хүн, нэг ээлжинд 57 хүн ажиллах бөгөөд гарах хог хаягдлыг ангилан хадгалж орон нутгийн тохижуулах газартай гэрээ хийж жилд 1 удаа ачуулж төвлөрсөн хогийн цэгт асгана.

Хэмжээ: Уурхай нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед 1 хүнээс хоногт 1.5 кг хуурай хог хаягдал гаран гэж тооцов. Нийт 57 хүн ажиллана. 1 хоногт гарах хог хаягдлын хэмжээ

урьдчилсан байдлаар 85,5кг, сард 2565 кг буюу 2.56 тн, жилд 155 хоног ажиллахад 13252.5 кг буюу 13.252 тонн хог хаягдал гарна.

Ахуйн шингэн хог хаягдлын хэмжээ: Ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 1153.6м3/жил ус хэрэглэнэ гэж усан хангамжийн хэсэгт тооцсоны дагуу үүний 70% нь хаягдал бохир ус гарна гэж үзвэл 346.08 м3/жил болно.

Химийн хортой бодис ашиглах: Төсөлд химийн аюултай бодис ашиглахгүй. Гэвч уурхайн техник тоног төхөөрмжийн тослох материал зэрэг химийн бодис агуулсан материалууд асгарах, хөрс орчныг бохирдуулах тул уурхайн засвар механикийн хэсгийн талбайг цементлэж хамгаалсан.

Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хийх арга хэмжээ

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Биелэлт	Хавсралт
1	Хог хаягдлын бүртгэлийг бий болгох	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгах ажлыг тогтмол хийх	Хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусгайлсан цэгт хадгалан ажилласан. Аюултай хог хаягдлын код авсан. Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагууруу нийлүүлэн ажилласан.	<i>Хавсралт 15. Хог хаягдлын сав, гэрээ, талбай, засварын төв</i>
2		Аюултай хог хаягдал болох ажилласан тос масло түр хадгалах сав болон аккумуляторыг тусгайлсан хэсэгт хадгалж гэрээний дагуу зайлуулах, бүртгэлжүүлэх ажлыг хэрэгжүүлэх		
3		Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулж цэгт нийлүүлэх		
	Уурхайн ажилчдын ахуйн болон автомашины гаралтай хог хаягдлыг ангилан	Уурхайд үүссэн хог хаягдлыг өөрийн техникээр 2догч түүхий эд болох шил, лааз, хуванцар савыг түүхий эдийн төвд хүргэх		
4	ялгаж зориулалтын цэг дээр хадгалаагүйн улмаас хөрс, гүний ус, агаар, ургамал, амьтан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Хог хаягдлын гэрээний дагуу хог хаягдал зайлуулах төлбөрийг төлөн ажиллах		
Нийт			650.0	

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 18. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

№	Хийж гүйцэтгэсэн ажлууд	Биелэлт	Хавсралт
1.	Өмнө жилүүдэд тарьсан модны усалгаа арчилгааг хийх, усалгааны систем байршуулах	Энэ жилийн хувьд мод арчилгааны ажилд анхааран ажилласан. Усалгааны систем шинээр авч байршуулан ажилласан. Кемпийн талбайд ногоон байгууламж нэмэн хиймэл нуур, усан оргилуур хийсэн.	Хавсралт 16. Усалгааны систем усалгаа
2.	Техникийн нөхөн сэргээлт 4га талбай	2023 онд 3,8 га 2024 онд 6 га 2025 онд 14,7га Нийт 24,5га	Хавсралт 17.Нөхөн сэргээлтийн зураг

5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 19. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн ахмгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт	Хавсралт
